



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,  
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2022.03.15 № 03/1161  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Санхүүжилтийн эрх нээлгэх тухай**

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтын Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XV.1.1.18-д “Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт (Улаанбаатар)” ажил батлагдсан. Энэ төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжих “Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт хэрэгжүүлэх авто замын төсөл, арга хэмжээ (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг) багц 6”-ын гүйцэтгэгчээр “Ди вай кэй би” ХХК ажилласан.

Энэ хууль болон Монгол Улсын Засгийн Газрын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор дээрх төсөл, арга хэмжээнд батлагдсан хөрөнгийн үлдэгдэл болох 82,339,288.0 төгрөгийг тус яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршуулсан.

Тус төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч “Ди вай кэй би” ХХК-ийн магадалшгүй ажлын гүйцэтгэл № 1-ийн 72,093,403.0 (далан хоёр сая ерэн гурван мянга дөрвөн зуун гурав) төгрөгийг хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг акт, төсөв болон гүйцэтгэлийн хамт хүргүүлж байна.

Иймд тус яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа хөрөнгөөс зохих журмын дагуу санхүүжилтийн эрхийг нээж өгнө үү.

Хавсралт...1...хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С.БАТБОЛД



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ХҮСЭЛТИЙН МАЯГТ

БАТЛАВ:  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА



С.БАТБОЛД

Санхүүжилтийн хүсэлт № 27

"Ди вай кэй би" ХХК

2022.03.15

| Төслийн дугаар | Төсөл арга хэмжээний нэр  | Гэрээгээр тохиролцсон өртөг | 2022 онд батлагдсан төсөв | Гэрээний дугаар | Нийт гүйцэтгэл       | Нийт санхүүжилт      | Өмнөх санхүүжилт     | Одоо санхүүжих    | Үлдэгдэл санхүүжилт | /төгрөгөөр/ |
|----------------|---|-----------------------------|---------------------------|-----------------|----------------------|----------------------|----------------------|-------------------|---------------------|-------------|
|                | Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт хэрэгжүүлэх авто замын төсөл, арга хэмжээ /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг/ Багц 6/-ийн магадлалгүй ажлын гүйцэтгэл № 1 | 5,551,120,902               |                           | № 180           | 5,537,918,527        | 5,537,918,527        | 5,465,825,124        | 72,093,403        | 13,202,375          |             |
|                | Урьдчилгаа санхүүжилт   |                             |                           |                 | 0                    | 0                    |                      |                   | 0                   |             |
|                | Урьдчилгааны эргэн төлөлт   |                             |                           |                 |                      |                      |                      |                   | 0                   |             |
|                | <b>Санхүүжилтийн эрх нээлгэх дүн</b>  |                             |                           |                 | <b>5,537,918,527</b> | <b>5,537,918,527</b> | <b>5,465,825,124</b> | <b>72,093,403</b> | <b>13,202,375</b>   |             |
|                | Захиалагчийн хяналтын зардал  | 83,624,605                  |                           |                 | 83,624,605           | 83,624,605           | 82,339,288           | 1,285,317         | 0                   |             |
|                | Норм нормативийн сан  | 18,610,672                  |                           |                 | 18,610,672           | 18,610,672           | 18,494,993           | 115,678           | 0                   |             |
|                | Барьцаа   | 277,556,045                 |                           |                 | 276,895,926          | 276,895,926          | 273,291,256          | 3,604,670         |                     |             |
|                | Гүйцэтгэгчид төлөх дүн  | 5,171,329,580               |                           |                 | 5,158,787,325        | 5,158,787,325        | 5,091,699,587        | 67,087,738        | 13,202,375          |             |

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Д.Гэрэлням

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Ч.Ренчиндамба

Боловсруулсан:

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч

Н.Баярсайхан